



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/41

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Өндөршил сумын ЕБС-ийн спорт заалны их засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Энхмэнд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Дүүрэнжаргал	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд	Б.Амгаланжаргал	(Өндөршил сумын ЗДТГ-ын дарга)
	Э.Төгсбаяр	(Зураг төсөл зохиогч "Чулуутын багш" ХХК-ийн архитектур)
	Х.Буянхүү	(Гүйцэтгэгч "Илч дулаан өсөх" ХХК-ийн захирал)
	Н.Цэрэндулам Т.Уранбайгаль	(Өндөршил сумын ЕБС-ийн захирал) (Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Э.Энхмэнд)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ

D/ Alban bichig/ Tushaal 2024.09.02

4824010159